Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

Газрын тос, бүтээгдэхүүний газар
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| № | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэл-ийн хувь | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | Өөрийн үнэлгээ | ХШҮ |
| Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 1.1. | Газрын тосны ордын ашиглалт, олборлолтыг урт хугацаанд тогтвортой хадгалж, боломжит хэмжээгээр нэмэгдүүлэх | Үйл ажиллагааны зардлаар | Газрын тосны олборлолтын тоо хэмжээ | 4.7 сая баррель буюу 645.5 мянган тонн | 4.8 сая баррель буюу 659.2 мянган тонн | - Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн. - Хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4.09 сая баррель буюу 555.6 мянган тонн. | 100% | 90% | |
| 1.1.1 | Олборлож буй тосны тоо хэмжээний нэгтгэлд хяналт | Үйл ажиллагааны зардал | Олборлолтын тоо хэмжээ | 4.7 сая баррель буюу 645.5 мянган тонн | 1.82 сая баррель буюу 247.3 мянган тонн | 4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн | Газрын тосны газрын даргын баталсан удирдамжийн дагуу /2024 оны 01 дүгээр сарын | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тавих, удирдлагаар хангаж ажиллах | | | | | | 08-ны өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI талбай, Дорноговь аймгийн Сайншанд сумын нутагт орших Бүтээгдэхүүн хуваах гэрээт 1997 оны талбайнуудад албан томилолтоор 143 хоног ажилласан./ албан томилолтоор ажилласан албан хаагчдад хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллав. /Петрочайна дачин тамсаг ХХК нь Тосон-Уул XIX талбайд олборлолтын | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тоног төхөөрөмж суурилуулсан нийт 486 цооног байгаа бөгөөд үүнээс нэгдсэн байгууламжид холбогдсон 400 цооног, холбогдоогүй 86 цооногоор хоногт дунджаар 4574 баррель, задгайгаар буюу цооног шавхалтад ашиглаж буй 364 цооног байгаагаас 72 цооногоор хоногт дунджаар 547 баррель, нийт 5121 баррель газрын тосыг хоногт олборлож байна. Тамсаг XXI талбайгаас 2024 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан 307 цооногоос 773,723 баррель, задгайгаар буюу цооног шавхалтаар | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 79,145 баррель, нийт 852,868 баррель буюу 116,701 тонн газрын тос олборлосон байна. Доншен Газрын тос (Монгол) ХХК нь БХГ-т 1997 оны талбайгаас 2024 онд 424,637 баррель буюу 59,390.0 тонн газрын тос олборлож, экспортлох төлөвлөгөөтэй байгаагаас 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан цооногуудаас 125,613 баррель буюу 17,568 тонн газрын тос олборлосон. 1997 оны БХГ-т талбайд олборлолтын тоног төхөөрөмж суурилуулсан нийт 188 цооног байгаа бөгөөд үүнээс дунджаар | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 129 цооногоор хоногт дунджаар 964 баррель олборлож байна. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр Монгол Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 4.19 сая баррель буюу 562.6 мянган тонн тос олборлохоор байна./ | | |
| 1.1.2 | Экспортолж буй тосны тоо хэмжээ, чанарын шинжилгээнд хяналт тавих, удирдлагаар хангаж ажиллах | Үйл ажиллагааны зардал | Экспортын тоо хэмжээ | 4.6 сая баррель буюу 622.8 мянган тонн | 1.82 сая баррель буюу 247.3 мянган тонн | 4.85 сая баррель буюу 659.2 мянган тонн | Газрын тосны газрын даргын удирдамжийн дагуу /2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн Газрын тосны ашиглалтын хэлтсийн мэргэжилтнүүд Дорнод аймгийн Матад сумын нутагт орших Тосон-Уул XIX, Халхгол сумын нутагт орших Тамсаг XXI талбай, Дорноговь | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн Сайншанд сумын нутагт орших Бүтээгдэхүүн хуваах гэрээт 1997 оны талбайнуудад албан томилолтоор 143 хоног/ ажилласан албан хаагчдад хяналт тавьж, удирдлагаар хангаж ажиллав. /Тосон-Уул XIX талбайгаас 2024 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар нийт 762,155 баррель буюу 101,135 тонн газрын тосыг БНХАУ руу экспортлов. Дунджаар өдөрт 20 автоцистернээр 5,210 баррель тосыг БНХАУ-д экспортолж байна. Экспортолж буй газрын тосны усны агуулга 0.03 хувь, дундаж нягт 835.2 кг/м3 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. Тамсаг XXI талбайгаас 2024 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар нийт 3,134 автоцистернээр 838,922 баррель буюу 115,744 тонн газрын тосыг БНХАУ руу экспортлоод байна. Дунджаар өдөрт 20 автоцистернээр 6,454 баррель тосыг БНХАУ-д экспортолж байна. Экспортолж буй газрын тосны усны агуулга 0.03 хувь, дундаж нягт 867.7 кг/м3 байна. БХГ-97 талбайгаас 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 18 удаагийн ачилтаар 153,377 баррель буюу 21,560 тонн газрын тосыг БНХАУ-д экспортолсон | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. Экспортолсон тосны усны агууламж 0.025 хувь, 15 градус дахь нягт 884.1 кг/м3. Монгол Улсын хэмжээнд нийт хүлээгдэж буй гүйцэтгэлээр 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар 2.08 сая баррель буюу 283.8 мянган тонн тос экспортлохоор байна./ | | |
| 1.2. | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, К-5 (Евро-5) стандартын шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагааны зардал | Дотоодын зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд өсөн нэмэгдэж буй хэрэглээтэй уялдуулан | 2023 онд 2.2 сая тонн | Эхний хагас жилд 1.2 сая тонн Сүүлийн хагас жилд 2.4 сая тонн | - Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 2.5 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлоод байгаа ба зорилтот түвшин болох 2.4 сая тоннд хүрсэн. Өсөн нэмэгдэж буй хэрэглээг тогтвортой | 100% | 100% | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | импортын хэмжээ, нийлүүлэлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх. | | | хангах хүрээнд нийлүүлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр ОХУ-ын нийлүүлэгч талуудтай хэлэлцэн, импортын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч, газрын тосны бүтээгдэхүүний гол ханган нийлүүлэгч ОХУ-ын Роснефть компанитай тогтмол харилцаатай ажиллаж, манай улсад нийлүүлэхээр илгээсэн газрын тосны бүтээгдэхүүний ачилтын болон вагоны мэдээг хүлээн авч, сар бүрийн импорт, дараа сарын захиалгын хэмжээнд тухай бүр | | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажилласаны үр дүнд энэ онд дотоодын зах зээл дээр газрын тосны бүтээгдэхүүний хангамж тогтвортой байсан. | | | |
| 1.2.1 | Дотоодын зах зээл дээрх газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах хүрээнд өсөн нэмэгдэж буй хэрэглээтэй уялдуулан импортын хэмжээ, нийлүүлэлтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлыг зохион | Үйл ажиллагааны зардал | Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ, тонн | 2.2 сая | 1.2 сая | 2.4 сая | - Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 2.6 сая тонн газрын тосны бүтээгдэхүүн импортлоод байгаа ба зорилтот түвшин болох 2.4 сая тонноос 200 мян.тн-оор илүү байна. Импортын хэмжээг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 17 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа ба бүтээгдэхүүний | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | байгуулах, дэмжлэг үзүүлэх. | | | | | | төрлөөр авч үзвэл Аи-92 автобензин 25 хувь, дизель түлш 24 хувиар тус тус өссөн бол А-80 автобензин 73 хувиар буурсан байна. - Улсын хэмжээнд 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар А-80 автобензин 18 хоног, Аи-92 автобензин 30 хоног, Аи-95 автобензин 53 хоног, дизель түлш 19 хоног, ТС-1 онгоцны түлш 15 хоногийн ердийн хэрэглээний үлдэгдэл, нөөцтэй байна. - Өсөн нэмэгдэж буй хэрэглээг тогтвортой хангах хүрээнд нийлүүлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр манай гол ханган нийлүүлэгч ОХУ-ын нийлүүлэгч талуудтай | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хэлэлцэн, импортын хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажилласны үр дүнд энэ онд дотоодын зах зээл дээр газрын тосны бүтээгдэхүүний хангамж тогтвортой байсан. ОХУ-ын Роснефть компанитай тогтмол харилцаатай ажиллаж, манай улсад нийлүүлэхээр илгээсэн газрын тосны бүтээгдэхүүний ачилтын болон вагоны мэдээг хүлээн авч, сар бүрийн импорт, дараа сарын захиалгын хэмжээнд тухай бүр хяналт тавьж, холбогдох арга хэмжээ авч ажилласан. | | |
| 1.2.2 | К-5 (Евро-5) стандартын | Үйл ажиллаг | Нийт шатахуунд | К5 /Евро-5/ стандартын | К5 /Евро-5/ стандарты | К5 /Евро-5/ стандартын | Улсын хэмжээнд 2024 оны 12 | 90% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шатахууны импорт, хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах. | ааны зардал | эзлэх К-5 /Евро-5/ ангиллын шатахууны эзлэх хувь. | шатахууны эзлэх хувь 14%. | н шатахууны эзлэх хувь 50%. | шатахууны эзлэх хувь 50%. | дугаар сарын 10-ны өдрийн байдлаар нийт 2.3 сая тонн шатахуун импортлон, хэрэглэснээс Евро-5 стандартын шатахуун 326.6 мянган тонн буюу нийт шатахууны 14 хувийг эзэлж байна. Манай гол ханган нийлүүлэгч орнууд болох ОХУ, БНХАУ-ын дотоодын зах зээлийн нөхцөл байдал дэлхийн зах зээл дэх газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний үнийн хэлбэлзэл зэрэг гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр 2024 онд К-5 /Евро-5/ стандартын шатахууны хувь хэмжээг зорилтот түвшинд хүргэж нэмэгдүүлэх боломж | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хязгаарлагдмал байсан болно.Тухайлбал, дайны нөхцөл байдалтай холбоотойгоор ОХУ-ын дотоод зах зээл дээр К-5 /Евро-5/ стандартын шатахууны эрэлт нэмэгдэж, экспортын хязгаарлалт хийсэн, мөн БНХАУ-ын төмөр замаас Монгол улс руу шатахуун тээвэрлэх вагоны зөвшөөрөл энэ оны 3 дугаар сараас хойш олгоогүй зэрэг шалтгаанаар нийлүүлэгч талаас К-5 /Евро-5/ стандартын шатахууныг захиалгын дагуу нийлүүлээгүй болно. | | |
| 1.2.3 | Баруун бүсийн шатахууны хэрэглээний | Үйл ажиллагааны зардал | Төслийн барилга, угсралтын ажлын | 0 | 50 | 100 | - Төсөл хэрэгжүүлэгч компани 2020-2022 онуудад | 100% | 70% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | тодорхой хувийг хангах зорилгоор Ховд аймагт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бага оврын газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад дэмжлэг үзүүлэх | | явц, хувь. | | | | Ховд аймгийн Жаргалант сумын нутагт үйлдвэрийн зориулалтаар 6.0га газар эзэмших зөвшөөрөл авч төслийн Байгаль орчинд нөлөөлөх байдлын Ерөнхий болон Нарийвчилсан үнэлгээний тайланг мэргэжлийн байгууллагаар хийлгэн, БОАЖЯ-ны Зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Мөн үйлдвэрийн агуулахын зураг төсөл боловсруулж, аймгийн Мэргэжлийн хяналтын газар, ОБЕГ, БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвөөр тус тус батлуулсан. Төсөл хэрэгжүүлэгч "Трансгейт интернэшнл" ХХК-аас Ховд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймагт хэрэгжүүлж байгаа газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрийн төсөл санхүүжилтын эх үүсвэр шийдэгдээгүй холбоотойгоор үйлдвэрийн төсөл түр зогсонги байдалд орood байгаа талаар 2023 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн А/38 дугаартай албан бичгийг манай байгууллагад ирүүлсэн. Улсын Их Хурлын 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 21 дугаар тогтоолоор Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан ба энэхүү хөтөлбөрт тус арга хэмжээ | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тусгагдаагүй болно. | | |
| Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ | | | | | | | | | |
| 3.1. | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулыг эрчимжүүлж нөөцийг өсгөнө. | үйл ажиллагааны зардал | Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. Хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | 2023 онд хайгуулын 9 талбайд ажил хийгдсэн. | Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. Хайгуулын ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн ирүүлсэн Засгийн газрын гишүүд (яамд)-ийн саналыг БХГ-нд тусгах, оруулах өөрчлөлтийг аж ахуй нэгжтэй тохиролцож, төслийг дахин ирүүлэхийг мэдэгдсэний дагуу саналыг тусгаж тохиролцсон эцсийн хувилбар бүхий БХГ-ний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэ | 100% | 100% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | эр 2024 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн 1/4158, 2024 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1/4213 тоот албан бичгүүдээр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд уламжилсан. Энэ ажлын үр дүнд Засгийн газрын 135, 136, 137, 165, 166, 167- р тогтоолоор АМГТГ-т БХГ байхгуулах эрх олгосон. Засгийн газрын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 135, 137, 165 дугаар тогтоолоор эрх олгосны дагуу манай газар Фойсон Энержи Монголиа ХХК-тай 2024 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 11 дүгээр сарын 21-ний өдөр, Юу Жи Эс ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр, Баянпетролиум ХХК-тай 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр тус тус БХГ-г байгуулсан. | | | |
| 3.1.1 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны хайгуулын талбайд сонгон шалгаруулалт зарлах бэлтгэл ажлыг хангах, захиалга хүлээн авах, гэрээлэгчийг сонгон шалгаруулах, хайгуулын талбайд болон эрлээс хайгуулд шилжиж байгаа | үйл ажиллагааны төрөл | Шинээр 2 талбайд БХГ байгуулсан байна. | 2023 онд 10 талбайд сонгон шалгаруулалт зарлаж, сонгон шалгаруулалтын үр дүнгээр 3, эрлийн ажлын үр дүнгээр 1, нийт БХГ-ний 4 төслийг УУХҮЯ-нд хүргүүлсэн. | Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д заасны дагуу ЗГ-аас эрх олгосон тоогоор БХГ байгуулсан байна. Сонгон шалгаруулалт болон эрлийн ажлын үр дүнгээр БХГ байгуулах хүсэлт | Газрын тосны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-д заасны дагуу ЗГ-аас эрх олгосон тоогоор БХГ байгуулсан байна. Сонгон шалгаруулалт болон эрлийн ажлын үр дүнгээр БХГ байгуулах хүсэлт ирсэн тоогоор ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, санал дүгнэлт гаргасан ажилд хяналт | Сонгон шалгаруулалт зарласан 4 талбайд шалгарсан санал болон эрлийн ажлын үр дүнгээр Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах 2 санал ирүүлсэнийг Бүтээгдэхүүн хуваах гэрээний загвар төслийн дагуу хэлэлцсэн гэрээний төсөлд Засгийн газрын яамдаас ирүүлсэн саналыг холбогдох ажлын хэсгүүд: | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах ажилд хяналт тавих. | | | | ирсэн тоогоор ажлын хэсэг байгуулагдан ажиллаж, санал дүгнэлт гаргасан ажилд хяналт тавих. | тавих. | 1. Газрын тосны хайгуулын “Хэрлэнтохой-XXVII” талбайн БХГ-ний төслийг 2024.10.07-ны өдөр Монголиа Фойсон Энержи ХХК-ийн төлөөлөлтэй 2. Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын “Ачит-XXXVII” талбайн БХГ-ний төслийг 2024.10.02-ны өдөр Тэмүүжин металс ХХК-ийн төлөөлөлтэй 3. Газрын тосны хайгуулын “Борзон-VII” талбайн БХГ-ний төслийг 2024.10.03-ны өдөр Петро матад энержи лимитед ХХК-ийн төлөөлөлтэй 4. Газрын тосны хайгуулын “Гурванбаян-XXX” талбайн БХГ-ний төслийг 2024.09.30-ны өдөр Баян петролиум ХХК- | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ийн төлөөлөлтэй 5. Нүүрсний давхаргын метан хийн хайгуулын “Төв-XXXVI” талбайн БХГ-ний төслийг 2024.10.03-ны өдөр Юу Жи Эс ХХК-ийн төлөөлөлтэй 6. Газрын тосны хайгуулын “Дарьганга-XXIV” талбайн БХГ-ний төслийг 2024.10.03-ны өдөр Петроматад ХХК-ийн төлөөлөлтэй Тус тус дахин хэлэлцээр хийж эцэслэн тохирсон БХГ-ний төслийн үзэглэсэн хувийг хэлэлцээрийн тэмдэглэлийн хамт Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд 2024.10.04-ны №1/4158, 2024.10.09-ний №1/4213 албан бичгүүдээр уламжилж | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Газрын тосны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д заасан шийдвэрийг гаргуулсан. | | |
| 3.1.2 | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийн ажил хийх хүсэлт хүлээн авч хянасан санал дүгнэлтх, холбогдох хууль дүрэм журмын шаардлага хангасан хуулийн этгээдтэй эрлийн гэрээ байгуулахад хяналт тавих, удирдлагаар хангах. | үйл ажиллагааны зардал | Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ 1-2 байгуулсан байна. | 2023 онд Эрлийн ажил гүйцэтгэх 2 гэрээ байгуулсан. | Эрлийн ажил гүйцэтгэх гэрээнд хяналт тавих. | Эрлийн ажил гүйцэтгэх гэрээнд хяналт тавих. | Ашигт малтмал, газрын тосны газарт Эрлийн гэрээ байгуулах хүсэлтүүд ирүүлсэнийг Газрын тосны тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу хүсэлтийн үндэслэл, Эрлийн гэрээний санал, нөхцөл, эрлийн ажлын төлөвлөгөө, төсөв зэргийг хяналтын тойрох хуудсаар холбогдох мэргэжилтнүүд хянан, мэргэжлийн дүгнэлт гаргаж гэрээний эцэслэсэн хувилбарыг удирдлагад танилцуулснаар дараах: 1. Оргих бүрд хишиг ХХК- | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тай нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээг 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр, 2. И Эс Жи Инвест ХХК-тай нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээг 2024 оны 01 сарын 24-ний өдөр, 3. Ийстерн газ эксплорэйшн ХХК-тай нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдөр, 4. Бөмбөлөгт эрдэс ХХК-тай нүүрсний давхаргын метан хийн эрлийн гэрээг 2024 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр тус тус 3 жилийн хугацаатай байгуулсан. | | |
| 3.1. | Газрын тос, | үйл | Хайгуулын | 2023 онд | 7 талбайн | Нэмэлтээр | 1/ Эрлийн гэрээт | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуулын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг батлах, түүний гүйцэтгэлд хяналт тавих. | ажиллагааны зардал | ажил, хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдсэн байна. | эрлийн ажлын 9, хайгуулын ажлын 13 төлөвлөгөө төсөв баталсан. | 2024 оны хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг БХГ болон төлөвлөгөө, төсөв зохиох зааварт нийцүүлэн баталсан байна. | ирүүлсэн тоогоор хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг зааварт нийцүүлэн баталсан байна. | 11 талбайн төлөвлөгөө, төсвийн эрлийн ажлын арга аргачлал, талбайд хийгдэх ажлын үндэслэл зэргийг холбогдох мэргэжилтнүүд хянасаны үр дүнд: 1. Жаргал инвестмент ХХК-ийн төлөвлөгөө, төсвийг засварт буцаасан. Батлагдаагүй, 2. Жейд газ Монголиа ХХК / Дорнынговь талбай/-ийн төлөвлөгөө, төсөв /2024-03-11/ баталсан, 3. Жейд газ Монголиа ХХК /Шивээговь талбай/-ийн төлөвлөгөө, төсөв /2024-03-11/ баталсан, 4. Баруун наран газ ХХК-ийн төлөвлөгөө, төсөв /2024-03-11/ баталсан, 5. Ууганбулаг ХХК-ийн төлөвлөгөө, төсөв /2024-03- | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 22/ баталсан, 6. Оргих бүрд хишиг ХХК-ийн төлөвлөгөө, төсөв 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр батлагдсан, 7. Си Эйч Би Ти Ти ХХК /Эрдэнэцагаан/-ийн төлөвлөгөө, төсөв /2024-07-30/ баталсан, 8. Хэнсүл констракшн ХХК-ийн төлөвлөгөө, төсөв /2024-06-24/ баталсан, 9. И Эс Жи Инвест ХХК-ийн төлөвлөгөө, төсөв /2024-07-18/ баталсан, 10. Ийстрен газ эксплорэйшн ХХК-ийн төлөвлөгөө, төсөв /2024-08-12/ баталсан, 11. Коммон макс ХХК-ийн төлөвлөгөө, төсвийг засварт буцаасан. Батлагдаагүй. Эрлийн ажил гүйцэтгэсэн тайлангийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | гүйцэтгэлд хяналтын хуудсаар мэргэжилтнүүд дүгнэлт гаргах ажил хийгдэж байна. 2/ Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайд 13 гэрээлэгчээс төлөвлөгөө, төсөв ирүүлснээс: 1. “Монголын Алт” /МАК/ ХХК 2024.01.09, 2. “Жи Өү Эйч” ХХК 2024.02.14, /2024.09.20 нэмэлт/, 3. “Метан газ ресурс” ХХК 2024.02.14 /2024.09.30 нэмэлт/, 4. “Смарт ойл Монголиа” ХХК 2024.02.28, 5. “Тэлмэн Ресурс” ХХК 2024.02.28 /2024.06.11 нэмэлт, 2024.09.30 нэмэлт/, 6. “Түмэн ойл” ХХК 2024.03.15, 7. “Капкорп Монголиа” ХХК | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2024.03.22, 8. “Тахь ресурс” ХХК 2024.03.25, 9. “Тахь ресурс” ХХК Богд 4 талбайд 2024.06.11-нд нэмэлт, 2024.09.11-нд нэмэлт, 10. Макс Ойл ХХК 2024.03.29, 11. Шунхлай энержи ХХК 2024.03.29, 12. Зон хэн юу тиан" ХХК 2024.05.27-ны өдрүүдэд тус тус /нийт 18 төлөвлөгөө, төсөв/ баталсан. 13. "Чайна Голден Сий Петролиум Эксплорэйшн Корпорэйшн" ХХК нь БХГ-ний үүрэг бүрэн гүйцэд биелүүлэх шаардлага хүргүүлж төлөвлөгөө, төсөв батлаагүй. | | |
| 3.1.4 | Эрэл, хайгуулын талбайд гүйцэтгэсэн | үйл ажиллагааны төрөл | Тайлан, материалыг хүлээн авч, БХГ- | 2023 онд 48 тайлан хүлээн авсан. | Газрын тос, уламжлалт бус газрын | Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, | Эрлийн гэрээт 3 талбайн үр дүнгийн тайлан, 2 талбайн | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | газрын тос, уламжлалт бус газрын тосны геологи, геофизик, гидрогеологи, геохими, өрөмдлөг, хайгуул, ашиглалттай холбогдсон үйл ажиллагааны анхдагч мэдээлэл, тайлан, материалыг хүлээн авах, хянах, мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх ажилд хяналт тавих. | | ний хайгуулын хугацаа дуусгавар болж буй 2 талбайн хайгуулын ажлын нэгдсэн тайланг мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | | тосны эрэл, хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайлангийн нэгтгэлд хяналт тавих. | хайгуул, ашиглалтын анхдагч болон үр дүнгийн тайлангийн нэгтгэлд хяналт тавих. | жилийн ажлын тайлан ирүүлснийг хянаж, 2 үр дүнгийн тайланг засварт буцааж, 1 үр дүнгийн тайланг Газрын тосны салбарын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн. Бүтээгдэхүүн хуваах гэрээт хайгуулын талбайн 34 тайлан ирүүлснийг хянаж шаардлага хангасан 24 тайланг хүлээн авч, 9 тайланг засварт буцааж, 1 тайланг хүлээж авахгүй талаар гэрээлэгч компанид албан бичиг хүргүүлсэн. Бүтээгдэхүүн хуваах гэрээт Галба-11 талбайн “Өлгий” ордын газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тооцооны тайланг 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж зохиогчийн хувилбараар хүлээн авсан бөгөөд “Ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэл”-д газрын тосны баталгаат нөөц 16.5 сая баррелиар нэмэгдсэн. | | |
| 3.1.5 | Эрлийн гэрээ болон Бүтээгдэхүүн хуваах гэрээний хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, батлагдсан төлөвлөгөөт ажлын гүйцэтгэлд хяналт тавих, удирдлагаар | үйл ажиллагааны зардал | Хайгуулын ажил, хөрөнгө оруулалт нэмэгдсэн байна. Батлагдсан хайгуулын ажлын төлөвлөгөөний тоогоор хайгуулын ажлыг эхлүүлж, | Номгон IX, Төхөм X /хойд/, Эргэл XII, Тавантолгой XXXIII, Гурвантэс XXXV, Т 1, Богд IV, Онги V талбайд 5 мэргэжилтэн 87 хоног хяналт тавьж ажилласан. | Хяналт тавьж, удирдлагаар хангасан байна. | Хяналт тавьж, удирдлагаар хангасан байна. | Эрлийн гэрээт ААН-үүд болон эрлийн талбайд хамаарах орон нутгийн удирдлагын холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 2024 оны №3/379, 1/669, 7/950, 3/1270, 3/1269, 3/1630, 3/1706, 3/2072, 7/2200, 7/2201, | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хангах. | | гүйцэтгэлд хяналт тавьсан байна. | | | | 7/2839, 3/2990, 3/3554, 3/3555, 3/3556, 3/3936 албан бичгүүд болон уулзалт, хэлэлцүүлэгүүд зохион байгуулж Газрын тосны тухай хууль, Эрлийн гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжийг хангахад шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, мэдэгдлийг цаг тухайд нь өгсөн. Бүтээгдэхүүн хуваах гэрээт ААН-үүд болон БХГ-т талбайд хамаарах орон нутгийн удирдлагын холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 2024 оны № 3/941, 3/4243, 4/4339, 1/4657, 1/4864, 3/2198, 3/2199, 3/941, 3/1873 албан бичгүүд болон уулзалт, хэлэлцүүлэгүүд | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зохион байгуулж Газрын тосны тухай хууль, Бүтээгдэхүүн хуваах гэрээ болон бусад холбогдох хууль тогтоомжийг хангахад шаардлагатай мэдээлэл, зөвлөгөө, мэдэгдлийг цаг тухайд нь өгсөн. АМГТГ-ын даргын 2024 оны №18 /2 хүн/, №23 /1хүн/, №30 /1 хүн/, №38 /4хүн/, №64 /2хүн/, №71 /1хүн/, №74 /2 хүн/ удирдамжийн дагуу Өмнөговь, Увс, Ховд, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод аймгуудад гүйцэтгэж байгаа Эрлийн гэрээт болон Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайнуудад эрэл, хайгуулын ажлыг газар | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дээр хяналт тавьж, холбогдох орон нутгийн удирдлага, төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж газрын тосны салбарын үйл ажиллагаа, гэрээний хэрэгжилтийг хангахад шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. | | |
| 3.1.6 | Гэрээлэгч нартай жилийн ажлын уулзалтыг зохион байгуулж 2022 онд хийгдсэн хайгуулын ажлын үр дүн, 2023 онд хийгдэх хайгуулын ажлын төлөвлөгөө төслийн талаар хэлэлцэж тулгамдаж | үйл ажиллагааны зардал | БХГ нь хүчин төгөлдөр 12 гэрээлэгчтэй жилийн ажлын уулзалтыг зохион байгуулсан байна. Гэрээний хэрэгжилтийг дүгнэсэн байна. | Газрын тосны хайгуулын 14 талбайн 12 гэрээлэгчтэй жилийн ажлын уулзалтыг зохион байгуулж, БХГ-ний 2022 оны хэрэгжилт, төлөвлөгөөний гүйцэтгэл, 2023 оны төлөвлөгөө, төсвийг хэлэлцсэн. | БХГ-ний 2023 оны хэрэгжилт, хайгуулын ажлын үр дүн, 2024 оны хайгуулын ажлын төлөвлөгөөг хэлэлцэх ажилд оролцох. | Шаардлагатай тоогоор тулгамдсан асуудлаар гэрээлэгчидтэй ажлын уулзалт зохион байгуулна. | АМГТГ-ын даргын 2024.01.03-ны өдрийн А/01 тушаалаар батлагдсан ажлын хэсэг БХГ-т 13 гэрээт талбайн “Жилийн ажлын уулзалт”-ыг 2024.01.05-ны өдрөөс 2024.04.03-ны хооронд зохион байгуулсан. Үүнд: 2024.01.05-нд “Монголын-Алт” ХХК-ийн Төхөм | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | буй асуудал дээр харилцан санал солилцон, бүтээгдэхүүн хуваах гэрээний тухайн жилийн хэрэгжилтийг дүгнэх ажилд хяналт тавих. | | | | | | X урд талбай, 2024.01.19-нд “Смарт ойл Монголиа” ХХК-ийн Эргэл XII талбай, 2024.01.24-нд “Жи Өү Эйч” ХХК-ийн Номгон IX талбай, 2024.01.25-нд “Тэлмэн ресурс” ХХК-ийн Гурвантэс XXXV талбай, 2024.01.26-нд “Тахь ресурс” ХХК –ийн Богд IV, Онги V, T1 талбайн, 2024.01.31-нд “Метан газ ресурс” ХХК-ийн Тавантолгой XXXIII талбай, 2024.02.28-нд “Түмэн-Ойл” ХХК-ийн Баянтүмэн XVII талбай, 2024.03.15-нд “Капкорп Монголиа” ХХК-ийн Онги V талбай, 2024.03.27-нд “Макс-Ойл” ХХК-ийн Арбулаг XXIX талбай, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 2024.03.29-нд “Шунхлай энержи” ХХК-ийн Сулинхээр XXIII талбай, 2024.04.03-нд "Зон хэн юу тиан"ХХК-ийн Галба XI талбайн 2023 тайлан, 2024 төлөвлөгөө, төсвийг тус тус хэлэлцсэн. Төрийн захиргааны төв байгууллага /УУХҮЯ/-д 2024.05.02-ны өдрийн №1/2010 албан бичгээр 2024 оны жилийн ажлын уулзалт түүнээс гарсан санал, цаашид авах арга хэмжээний талаар илтгэсэн. | | |
| 3.2. | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх төлбөр урамшуулал, орлогыг тооцож, нэхэмжлэн төвлөрүүлэх | үйл ажиллагааны зардал | Орлогын тооцооллыг сар бүр хийж, нэхэмжлэхийг газрын тосны олборлолтын үйл ажиллагаа | Гэрээлэгчдийн 2023 онд 304.16 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. | Нийт 361.5 тэрбум төгрөгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төвлөрүүлдэг төлбөр, урамшууллыг тооцож, нэхэмжлэн ажилласан | 100% | 90% | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах | | явуулж буй 2 компанид хүргүүлсэн байна | | | бөгөөд 2024 оны 12 дугаар сарын байдлаар нийт 14 гэрээлэгч нарт албан бичгийг хүргүүлэхэд хяналт тавин ажилласан. Тусгай зөвшөөрлийн төлбөрт 2.0 тэрбум төгрөг, сургалтын урамшуулалд 2.9 тэрбум төгрөг, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг (ТГҮАДТ)-ийн төлбөрт 2.0 тэрбум төгрөг тус тус төвлөрүүлсэн. | | | |
| 3.2.1 | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх төлбөр урамшуулал, орлогыг тооцож, | үйл ажиллагааны зардал | Улсын төсөвт төвлөрүүлсэн орлогын хэмжээ | 304.16 тэрбум төгрөг | 135.5 тэрбум төгрөг | 361.5 тэрбум төгрөг | Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу 37.2 сая ам.долларын тосны экспортын орлого болон 1.1 сая ам.долларын | 100% | 90% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэхэмжлэн төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах ажилд хяналт тавих. | | | | | | төлбөр, урамшууллыг төвлөрүүлсэн. Засгийн газрын 2018 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах журам”-ын дагуу гэрээлэгч компаниудын 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 03 дугаар сард төлсөн нөөц ашигласны төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 30 хувийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд, тусгай зөвшөөрлийн төлбөрийн 70 хувийг улсын төсөвт, 20 хувийг тухайн аймаг, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нийслэлийн төсөвт, 10 хувийг сум, дүүргийн төсөвт хуваарилах тооцоог аймаг, нийслэл, сум, дүүрэг тус бүрээр хийж, дүн мэдээг сар бүр Сангийн яаманд 4/109, 1/161, 3/1056, 1/1686, 1/2105 дугаартай албан бичгүүдээр хүргүүлсэн. 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 06 дугаар сард нөөц ашигласны төлбөр нийт 20.7 тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт 14.5 тэрбум төгрөг, орон нутгийн хөгжлийн нэгдсэн санд 6.2 тэрбум төгрөг, тусгай зөвшөөрлийн төлбөр нийт 1.5 тэрбум төгрөг төвлөрүүлснээс улсын төсөвт 808,3 сая төгрөг, | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 18 аймгийн төсөвт (давхардсан тоогоор) 382.4 сая төгрөг, сумын төсөвт 64 (давхардсан тоогоор) 115.4 сая төгрөг тус тус хуваарилагдсан байна. 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар газрын тосны экспортын борлуулалтын орлогоос нийт 125.2 тэрбум төгрөгийг Улсын төсөвт төвлөрүүлсэн ба 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хүлээгдэж буй гүйцэтгэлээр 149.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр байна. | | |
| 3.3. | Газрын тосны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлыг | үйл ажиллагааны зардал | Хууль болон Бүтээгдэхүүн хуваах гэрээнд нийцсэн | Холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна. | Холбогдох хууль, тогтоомжид нийцсэн байна | 2024 онд Тосон Уул XIX талбай 104.4 сая ам.доллар, Тамсаг XXI | 100% | 90% | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулах, Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан үйл ажиллагааг явуулж буй аж ахуйн нэгжид хяналт тавина. | | байна. | | | талбай 135.8 сая ам.доллар, Матад XX талбай 15.2 сая ам.доллар, 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбай 31.3 сая ам.долларын хөрөнгө оруулалтын ажил хийхээр ажлын төлөвлөгөө, төсвийг батлуулсан. Бүтээгдэхүүн хуваах гэрээт газрын тосны ашиглалтын талбайнуудын 2024 оны батлагдсан ажлын төлөвлөгөө, төсөв 286.4 сая ам.доллар байгаа нь 2023 оны батлагдсан ажлын төлөвлөгөө, төсвөөс 1.3 дахин бага | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. Энэ нь газрын тосны олборлолт, экспортын үйл ажиллагаанд төрийн бус байгууллагын шууд болон шууд бус нөлөөлөл, хууль эрх зүйн орчны тогтвортой бус байгаатай холбоотой байна. Петрочайна дачин тамсаг ХХК-ийн Тосон Уул XIX, Тамсаг XXI талбай, Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн 1997 оны бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн БХГ-г Газрын тосны тухай хууль, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх асуудлаар | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 199 дүгээр захирамжаар “Гэрээлэгч хоёр компанитай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх хэлэлцээ хийх Монголын талын ажлын хэсэг” байгуулагдсан. Уг ажлын хэсэг болон УУХҮЯ-г мэдээллээр ханган ажилласан. Үүний дараа тухайн ажлын хэсгийг дахин шинэчлэж, Монгол Улсын Ерөнхий | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сайдын 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 30 дугаар захирамжаар "Петрочайна дачин тамсаг ХХК болон Доншен Газрын тос (Монгол) ХХК-тай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шинэчлэх хэлэлцээ хийх Монголын талын ажлын хэсэг" байгуулагдсан. Тус ажлын хэсэгт шаардлагатай мэдээлэл, тооцоолол, тайлбар зэргийг хүргүүлсэн. Мөн гэрээ шинэчлэх асуудлын талаарх | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | санал, дүгнэлтээ Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд хүргүүлсэн. | | | |
| 3.3.1 | Тосон-Уул XIX, Тамсаг XXI, Матад XX, 1997 оны Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2024 онд гүйцэтгэх ажлын төлөвлөгөө, төсвийн төслийг судалж, санал дүгнэлт гаргаж, батлуулах ажилд хяналт тавих. | үйл ажиллагааны зардал | Санал, дүгнэлтэд үндэслэж, баталсан төлөвлөгөө, төсвийн тоо | 4 | 4 | 4 | Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/04 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт ажиллаж 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төсөлд санал дүгнэлт өгч, “Петрочайна дачин тамсаг” ХХК-ийн Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан. “Доншен газрын тос (Монгол)” ХХК-ийн 1997 оны | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр батлуулсан. Петроматад ХХК-ийн Матад XX талбайн 2024 оны ажлын төлөвлөгөө, төсвийг 2024 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр батлуулсан. | | |
| 3.3.2 | Тосон-Уул, Тамсаг, Зүүнбаян, Цагаан-Элс, Цэнтогоруу газрын тосны ордын 2023 оны нөөцийн хөдөлгөөний нэгтгэсэн тайлан, дүгнэлтэд хяналт тавих. | үйл ажиллагааны зардал | Санал дүгнэлт гаргаж, хянасан тайлангийн тоо | 3 | 4 | 4 | Газрын тосны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын дагуу “Газрын тосны баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланд тавих шаардлага” журмыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн Сайдын 2022 оны 11 дүгээр сарын 16-ны | 100% | 90% |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | өдрийн А/287 дугаар тушаалаар баталсан. Үүний дагуу Тосон-Уул, Тамсагийн газрын тосны ордын нөөцийн тооцооны тайлангийн тодотгол, дахин тооцооллын ажлыг гүйцэтгэж байна. Өнөөдрийн байдлаар Петрочайна дачин тамсаг ХХК-ийн толгой компани болох БНХАУ-ын Газрын тос, хийн хайгуул, ашиглалтын үндсэн корпорациар хянуулах ажлыг гүйцэтгэж байна. Доншен газрын тос (Монгол) ХХК-ийн хувьд Зүүнбаян, Цагаан-Элсний ордын газрын тосны нөөцийн дахин тооцооллын тайлангийн төслийг 2024 | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 34/24 дугаар албан бичгээр ирүүлсэн ба тухайн тайланг засаж, сайжруулах талаар саналаа гэрээлэгчид хүргүүлсэн. Газрын тосны ашиглалтын жилийн тайлан, нөөцийн хөдөлгөөний тайланг Доншен газрын тос (Монгол) ХХК нь 2024 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр 02/24, Петрочайна дачин тамсаг ХХК нь 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 24/3-421 дугаар албан бичгээр ирүүлсэн ба тухайн тайлангуудыг хүлээж авсан. | | |
| 3.3.3 | Гэрээлэгчдийн өртөг нөхөгдөх зардлын | үйл ажиллагааны зардал | Хянан шалгаж, ҮАГ-т хүргүүлсэн | 28 | - | 16 | Гэрээлэгчдийн 2023 оны 4 дүгээр улирлын өртөг нөхөгдөх | 100% | 100 % |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | нэгтгэсэн тайланд хяналт тавих. | | тайлангийн тоо | | | | зардлын тайланг хүлээн авч нэгтгэв: Ашиглалтын 3 гэрээлэгчийн 4 талбайд нийт 128.1 сая ам.доллар, хайгуулын 8 гэрээлэгчийн 10 талбайд 23.2 сая ам.долларыг өртөг нөхөгдөх зардлын тайланд тайлагнасныг хүлээн авч нэгтгэв. Нийт дүнгээр 2023 оны хөрөнгө оруулалтын хэмжээ 155.4 сая ам.доллар: үүнээс өртөг нөхөгдөх зардлын хэмжээ 151.2 сая ам.доллар. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 8.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Гэрээлэгчдийн 2024 оны 1 дүгээр улирлын өртөг нөхөгдөх | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зардлын тайланг хүлээн авч нэгтгэн үзэхэд: Ашиглалтын 3 гэрээлэгчийн 4 талбайд 23.8 сая ам.доллар, хайгуулын 8 гэрээлэгчийн 9 талбайд 1.8 сая ам.доллар, нийт 25.6 сая ам.долларын зардлын өртгийг нөхөхөөр тайлагнасан байна. АМГТГ-ын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/15 тоот тушаалаар байгуулагдсан “Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны ашиглалтын үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгчдийн 2022 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | нөхөгдсөн зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтын тайланд хяналт, шалгалт хийж, дүгнэлт гаргах”,05 дугаар сарын 24-ний өдрийн А/66 дугаар тушаалаар “Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуулын үйл ажиллагаа эрхэлж буй гэрээлэгчдийн 2023 онд батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу гүйцэтгэсэн ажил, хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх зардлын тайланд хяналт шалгалт хийх" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хүрээнд: Хяналт, шалгалт хийх | | |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тухай 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн 3/510, 05 дугаар сарын 28-ны өдрийн 3/2370 дугаартай албан бичгийг 15 гэрээлэгчдэд хүргүүлсэн. Тамсаг XXI талбай, Матад XX талбайн хяналт шалгалтыг хийж шалгалтын дүгнэлтийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 07-ний өдрийн 3/2048, 15-ний өдрийн 3/2202 дугаартай албан бичгүүдээр санал авахаар гэрээлэгчдэд хүргүүлсэн. | | |

*Үнэлсэн:* .........................

*..........................................* *.........................* */................................/*

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

*.........................*

*(огноо)*

*Тайлагнасан:* .........................

.......................................... ......................... /................................../

*(албан тушаал )* *(гарын үсэг)*

.........................

*(огноо)*